



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

ӨВЧНИЙ ТҮҮХ БИЧИХ ЖУРАМ ШИНЭЧЛЭН
БАТЛАХ ТУХАЙ

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/485, 2019 оны А/611, А/406 тоот тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс өвчний түүх бичих журмыг нэгдүгээр, Эмч нарын хамтарсан үзлэг хийх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн мөрдөж ажиллахыг сэргээн засах төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын багийн ахлагч /Н.Дарьсүрэн/, статистик бүртгэл мэдээллийн ажилтан /Ө.Болорцэцэг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА *Ш. Саруултуяа* Ш.САРУУЛТУЯА



Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн
даргын 2021-оны 06 сарын 17-өдрийн
дугаар тушаалын 1-дүгээр хавсралт

A/sy



Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс өвчний түүх бичих журам

1. Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Өвчний түүх нь сэргээн засах төвийн үйлчлүүлэгчид хийгдэж буй оношилгоо, эмчилгээний явц, үр дүнг тусгасан эрх зүйн баримт бичиг мөн.
- 1.2. Өвчний түүх нь хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн нууцын зэрэгт хамаарахаас гадна сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, хуулийн баримт бичиг болно.
- 1.3. Энэхүү журмыг хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн эмч нар нь оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, заавар, зөвлөмжийг баримтлан үйлчлүүлэгчид оношилгоо, эмчилгээ хийх үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

2. Хоёр. Өвчний түүх хөтлөх

2.1. Өвчний түүхэнд тавигдах ерөнхий шаардлага

- 2.1.1. Өвчний түүхийг эх хэл дээр, хөх өнгийн тосон бал болон үзгээр гаргацтай бичнэ. Арилгадаг үзэг, балаар бичихийг хориглоно.
- 2.1.2. Эмч нэрээ гаргацтай бичнэ.
- 2.1.3. Зарим онош, нэр томъёог орос, латинаар бичиж болно.
- 2.1.4. Өвчний түүхэнд үйлчлүүлэгчийн биеийн байдал, зовуурь, бодит үзлэг, өвчний явц, оношилгоо, эмчилгээний төлөвлөлт, тусламж үйлчилгээний тухай тэмдэглэлийг тодорхой бичнэ.
- 2.1.5. Өвчний түүхийн тэмдэглэлийг өдөдр бүр хөтлөх ба цаг, минутыг тодорхой бичнэ.
- 2.1.6. Үйлчлүүлэгч хурц өвчнөөр өвдсөн үед түүнд хийсэн үзлэг, оношилгоо, эмчилгээг тухай бүрт цаг, минутаар заасан тэмдэглэл хөтөлнө.
- 2.1.7. Үйлчлүүлэгчийн өдөр тутмын амин үзүүлэлт, хийгдсэн сувилгаа, сэргээн засах эмчилгээг сувилагч амин үзүүлэлт хянах хуудас, хоол сувилгааны хуудсанд тэмдэглэл хөтөлнө.
- 2.1.8. Өвчний түүхийн эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг эмчлэгч эмч хариуцна.

2.2. Паспортын хэсэг

- 2.2.1. Энэ хэсгийн асуумж бүрийг хариулж бичиж тэмдэглэнэ.

- 2.2.2. Сэргээн засах төвд явуулсан байгууллага, эмчийн нэр, оношийг гаргацтай бичнэ.
- 2.2.3. Сэргээн засах төвд ирсэн, гарсан, үзлэг эхэлсэн огноог тодорхой бичнэ.
- 2.2.4. Хүлээн авсан эмч оношоо үзлэгийн тэмдэглэлийн төгсгөлд болон паспортын хэсгийн "Сэргээн засах төвийн эмчийн онош" хэсэгт бичнэ. Үндсэн онош тавигдсан даруйд эмчлэгч эмч уг оношийг паспортын хэсгийн зохих хэсэгт бичиж тэмдэглэнэ.
- 2.2.5. Өвчний түүхийг тасгийн эрхлэгч хянаж, гарын үсгээр баталгаажуулна.

2.3 Асуумж цуглуулах

- 2.3.1 Өвчний асуумж нь үйлчлүүлэгчийн зовуурь, шаналгааг тодруулахаас эхэлнэ.
- 2.3.2 Тухайн үйлчлүүлэгчид илрэх гол, бодит, тулгуурлах, санаа авах зовууриудыг дараалуулан бичнэ.
- 2.3.3 Өвчний явц, амьдралын түүхийг онош зүйн зарчмын дагуу баримтжуулж тэмдэглэнэ.
- 2.3.4 Асуумж цуглуулах явцад үйлчлүүлэгчийн ухаан санааны байдалд үнэлгээ өгнө.
- 2.3.5 Бага насны хүүхэд, асуултанд хариулах чадамжгүй үйлчлүүлэгчийн асуумжийг эцэг, эх, түүний асран хамгаалагч нараас асууж лавлана

2.4 Бодит үзлэг

- 2.4.1 Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг маш хүнд, хүнд, хүндэвтэр, дунд, хөнгөн гэсэн байдлаар үнэлнэ.
- 2.4.2 Үзлэг хийхдээ "толгойноос хөл хүртэл" гэсэн зарчмыг баримталж, нүцгэн биеийн үзлэг хийнэ. Арьс салст, өөхөн давхраа, булчин, үе мөч, дотор эрхтэний үзлэгийг харах, тэмтрэх, тогших, чагнах аргаар хийж, эрхтэн тус бүрээр тэмдэглэнэ
- 2.4.3 Амьсгал, судасны лугшилтийг тоолж, биеийн халуун, захын судасны хүчилтөрөгчийн ханамж зэргийг хэмжиж тэмдэглэсэн байна.
- 2.4.4 Хүүхдийн хөдөлгөөн, сэтгэхүйн онцлогийг DENVERII-аар үнэлж өвчний түүхэнд тусгана.

2.5 Шинжилгээ бүрдүүлэх

- 2.5.1 Шаардлагатай шинжилгээг хугацаа алдалгүй бүрдүүлнэ.
- 2.5.2 Шинжилгээ бүрийн үзүүлэлтийг дүгнэн, оношилгоо, эмчилгээнд тусгасан байна.

2.6 Оношлох

- 2.6.1 Онош нь зөв, дэлгэрэнгүй гэсэн шаардлагыг хангасан байна.
- 2.6.2 Оношийн үндэслэлийг гаргахдаа асуумж, бодит үзлэг, шинжилгээний өөрчлөлтийг дүгнэн ялган оношилгоо хийсэн байна.
- 2.6.3 Оношийг орос, монгол, англи хэлний аль нэгээр, үг, үсэг, дүрмийн алдаагүй, товчлохгүй, цэвэр, гаргацтай бичнэ. Оношийг Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу бичиж болно.
- 2.6.4 Оношийг ЭМС-ын 2019 оны A/611 тушаалын Эрүүл мэндийн бүртгэл СТ 1 дүгээр маягтын дагуу үндсэн онош, хүндрэл, дагалдах онош гэсэн дарааллыг баримтлан бичнэ.

2.7 Эмчлэх

- 2.7.1 Сэргээн засах эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- 2.7.2 Эмчилгээг хоол, дэглэм, өвчний шалтгаан, эмгэг жам, шинж тэмдэгт чиглэсэн үндсэн зарчмаар оношилгоо эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу бичнэ.
- 2.7.3 Эмчилгээг өвчний түүхэнд тухайн үзлэгийн тэмдэглэлийн ард бичсэн байна.
- 2.7.4 Эмчлэгч эмч эмчилгээг хуудас эргүүлэх бүрт бичнэ. Харин хуудас эргээгүй, эмчилгээ өөрчлөгдөөгүй үед "Эмчилгээ хэвээр" гэсэн үг хэрэглэж болно
- 2.7.5 Эмчилгээний өөрчлөлтийг тухай бүрт тусгаж бичнэ.
- 2.7.6 Эмийн нэрийг олон улсын нэршлээр, латинаар, харин хэрэглэх зааврыг монгол хэлээр бичнэ.

2.8 Дүгнэлт бичих

- 2.8.1 Сэргээн засах эмчилгээний хяналтын хуудас хөтлөж явцын дүгнэлт гарган ажиллана
- 2.8.2 Үйлчлүүлэгч сэргээн засах төвөөс гарсан үед гарах үеийн дүгнэлтийг бичнэ. Дүгнэлтэндээ хүүхдийн хөдөлгөөн сэтгэхүйн хөгжил (3 сар тутам DENVERII- үнэлэх) болон сэргээн засах эмчилгээний үр дүн хийгдсэн эмчилгээний тухай тусгаж бичнэ.

2.9 Үүрэг хариуцлага

- 2.9.1 Эмчлэгч эмч нь өвчний түүхийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллана
- 2.9.2 Үйлчлүүлэгчийн нууцийг хадгална

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн
даргын 2021 оны 06 сарын 17 өдрийн
А/59 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт

ЭМЧ НАРЫН ХАМТАРСАН ҮЗЛЭГ ХИЙХ ЖУРАМ

Сэргээн төвд хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн эмчилгээ, оношлогоо, тусламж үйлчилгээг эмчлэгч эмч хариуцан гүйцэтгэх бөгөөд тасгийн эрхлэгч, чанарын менежерүүд явцын хяналтыг хийж, үр дүнг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын багийн ахлагчид танилцуулж ажиллана. Сэргээн засах төвийн тусламж үйлчилгээг хэлэлцэх үйл ажиллагааг нь дараах үндсэн хэлбэртэй байна. Үүнд:

Нэг. Тасгийн эрхлэгчийн тойрон үзлэг

- 1.1 Тасгийн эрхлэгч хүнд өвчтөний биеийн байдалд эмчлэгч эмчийн нэгэн адил анхаарал, хяналт тавьж, эмчилгээ оношлогооны асуудлыг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.2 Долоо хоног бүрийн тогтсон нэг өдөрт эмч нарын тойрон үзлэгийг тасгийн эрхлэгч удирдан зохион байгуулж хариуцсан хэсгийн сувилагчаас үйлчлүүлэгчийн биеийн байдал, гарсан өөрчлөлтийн талаар мэдээллийг сонсож, цаашдын асуудлаар харилцан санал солилцон, арга зүйн зөвлөгөө өгнө.
- 1.3 Тасгийн эрхлэгчийн тойрон үзлэгээр эмчлэгч эмч тухайн үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээний талаарх товч мэдээллийг тасгийн эрхлэгч болон эмч нарт танилцуулан тэдний саналыг сонсож, өвчний түүхэнд тодорхой тэмдэглэл хөтлөж, тасгийн эрхлэгч, эмчлэгч эмчийн гарын үсэг зурна.
- 1.4 Тасгийн тойрон үзлэгийн үед үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээний талаар гарсан асуудлыг эмчлэгч эмч шийдвэрлэж, тасгийн эрхлэгч, эмч нарт эргэн мэдээлж, тасгийн эрхлэгч гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
- 1.5 Тойрон үзлэгийн дүнгээс үндэслэн эмнэл зүйн зөвлөгөөн, эмч нарын хамтарсан зөвлөгөөн зохион байгуулах эсэх асуудлыг эмчлэгч эмч, тасгийн эрхлэгч хариуцна.

Хоёр. Эмч нарын хамтарсан зөвлөгөөн

- 2.1 Эмч нарын хамтарсан зөвлөгөөнийг амь тэнссэн, маш хүнд, үйлүүлэгчийн онош тодорхойгүй, эмчилгээний асуудал маргаантай тохиолдолд оношлогоо, эмчилгээний асуудлыг яаралтай шийдвэрлэх зорилгоор зарлан хуралдуулна.
- 2.2 Эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийх шийдвэрийг эмчлэгч эмчийн, амбулаторийн эмчийн саналыг, түүнчлэн тасгийн тойрон үзлэгийн дүгнэлтийг

тус тус үндэслэн тасгийн эрхлэгч гаргана.

- 2.3 Тасгийн эрхлэгч эмч нарын хамтарсан зөвлөгөөнийг удирдан, зөвлөгөөний бүрэлдэхүүнийг зөвлөх эмчтэй хамтран томилж, “Эмч нарын хамтарсан зөвлөгөөн зарлах хуудас”-аар баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд гэрээт зөвлөх эмч, нарийн мэргэжлийн эмч нарыг урьж оролцуулж болно.
- 2.4 Эмч нарын зөвлөгөөний товыг заавал урьдчилан зарлах бөгөөд яаралтай тохиолдолд тухайн цагт оролцох бүрэлдэхүүнд мэдэгдэнэ.
- 2.5 Эмчлэгч эмч шаардлагатай шинжилгээнүүдийг бүрэн бүрдүүлж, зөвлөгөөний бэлтгэлийг хангаж, үзлэг хийх нөхцлийг бүрдүүлсэн байх ба зөвлөгөөнд үйлчлүүлэгчээ биечлэн танилцуулна.
- 2.6 Зөвлөгөөний тэмдэглэл, шийдвэр, дэгнэлтийг тасгийн эрхлэгчийн томилсон эмч өвчний түүхэнд дэлгэрэнгүй бичиж, зөвлөгөөнд оролцсон эмч нарын гарын үсэг зуруулж, баталгаажуулна.
- 2.7 Эмчлэгч эмч нь зөвлөгөөний бүрэлдэхүүнтэй хамтран эмчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээний тактикийг боловсруулж, эмнэл зүйн шийдвэрийг өөрийн санал дүгнэлттэй уялдуулан гаргана.
- 2.8 Тасгийн эрхлэгч нь эмч нарын хамтарсан зөвлөгөөний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 2.9 Шаардагдах шинжилгээ, рентген зураг нь чанарын шаардлага хангаагүйгээс шийдвэрт хүрч чадаагүй бол эмчлэгч эмч хариуцлагыг хүлээнэ.
- 2.10 Бэлтгэл бүрэн хангагдаагүй тохиолдолд зөвлөгөөний хойшлуулах, цуцлах шийдвэрийг зөвлөх эмч гаргаж болно.
- 2.11 Хүндэтгэх шалтгаангүйгээр зөвлөгөөнд оролцоогүй эмч мэргэжилтэнд төвийн дарга холбогдох журмын дагуу хариуцлага тооцно.

Гурав. Зөвлөх эмчийн үйл ажиллагаа

- 3.1 Төв нь хүүхдийн сэргээн засах чиглэлээр зөвлөх эмчийг гэрээтээр ажиллуулах бөгөөд зөвлөх эмчийн үйл ажиллагаанд төвийн дарга хяналт тавин ажиллана.
- 3.2 Зөвлөх эмчид үзүүлэх үйлчлүүлэгчийн талаар эмчлэгч эмч болон тасгийн эрхлэгч нар утсаар, цахим байдлаар, биеэр мэдээллийг өгч, шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг алдалгүй хийсэн байна.
- 3.3 Эмчлэгч эмч зөвлөх эмчид үйлчлүүлэгчийг танилцуулж, үзүүлэх бэлтгэлийг хангасан байна.
- 3.4 Зөвлөх эмч үзлэг хийсэн тухай тэмдэглэл, цаашдын эмчилгээ, оношлогоонд өгөх санал, зөвлөгөөнийг өвчний түүхэнд бичиж, гарын үсгээ зурж

баталгаажуулна.

3.5 Зөвлөх эмчийн зөвлөгөө, шийдвэрийн хэрэгжилтэнд тасгийн эрхлэгч хяналт тавина.

3.6 Зөвлөх эмч нь гэрээнд заасны дагуу сургалт, боловсон хүчний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд оролцож, сургалтыг хөтөлбөрийн дагуу явуулж хамтран ажиллана.